

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.05.05

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P 500 индекс нэгдүгээр сараас хойш анх удаагаа хоёр долоо хоног дараалан өссөн.
- Долоо хоногийн эхэнд гадаад худалдааны зөрчил зөөлрөх төлөвтэй.
- Дөрөвдүгээр сард 177,000 ажлын байр шинээр нэмэгдсэн нь өмнөх сараас бага хэдий ч 135,000 гэсэн таамгийг давсан үзүүлэлт боллоо.
- АНУ-ын эдийн засаг 2025 оны I улиралд агшлаа.
- тавдугаар сарын 1-нээс 5-ны өдрүүдэд Хөдөлмөрийн баярын амралтаар хаалттай байгаа бөгөөд арилжаа тавдугаар сарын 6-ны Мягмар гарагт дахин эхэлнэ.
- Хятад улс АНУ-аас оруулж буй ойролцоогоор 40 тэрбум ам.долларын импортын бараанд ногдуулсан тарифын заримыг хөнгөлөхөөр ажиллаж буй тухай Bloomberg агентлаг мэдээллээ.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Golomt_Capital published on TradingView.com, May 04, 2025 23:42 UTC+4

S&P 500 E-mini Futures - 1M1 - CME 05,617.50 H5,724.75 L5,601.00 C5,671.50 +52.25 (+0.93%) -39.00 (-0.68%)





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.04.28-05.04

ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫН ТАЙЛАН САЙН ГАРЛАА

АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлттэй хаагдав. S&P 500 индекс нэгдүгээр сараас хойш анх удаагаа хоёр долоо хоног дараалан өссөн бөгөөд өнгөрөгч баасан гарагийн байдлаар S&P500 индекс есөн өдөр дараалан ногоон хаагдсан байна.

Харин технологийн салбар давамгайлсан Nasdaq Composite индекс 3.42%-иар өсч, томоохон технологийн компаниудын хүлээлтээс давсан тайлан энэ өсөлтийг дэмжжээ. Мөн жижиг болон дунд хэмжээний компанийн индексүүд дөрөв дэх долоо хоног дараалан өссөн байна. Долоо хоногийн эхэнд гадаад худалдааны зөрчил зөөлрөх төлөвтэй болсноор зах зээл сэргэхэд гол нөлөө үзүүлсэн бөгөөд тодруулбал Ерөнхийлөгч Дональд Трамп зарим автомашины эд ангийн тарифыг цуцалсан нь үүнд голлон нөлөөлжээ.

Түүнчлэн Худалдааны нарийн бичгийн дарга Ховард Лутник томоохон худалдааны хэлэлцээр эцэслэх шатандаа орсныг зарласан байна. Харин долоо хоногийн сүүлчээр анхаарал голчлон орлогын тайланд төвлөрсөн бөгөөд S&P 500 индексийн нийт зах зээлийн үнэлгээний ойролцоогоор 40 хувийг бүрдүүлдэг компаниуд эхний улирлын санхүүгийн үр дүнгээ танилцуулсан. Үүнд алдартай "гайхамшигт долоо"-гийн дөрвөн компанийн тайлан багтжээ.

АЖЛЫН БАЙРНЫ ТОО БУУРЛАА

АНУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд холимог дохио өглөө. Ажлын байрны тоо буурсан ч ажил эрхлэлт хүчтэй хэвээр байна. Баасан гарагт BLS-ээс нийтэлсэн албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн тайлан таамгаас давсан үр дүн үзүүлсэн юм. Дөрөвдүгээр сард 177,000 ажлын байр шинээр нэмэгдсэн нь өмнөх сараас бага хэдий ч 135,000 гэсэн таамгийг давсан үзүүлэлт боллоо. Ажилгүйдлийн түвшин 4.2%-д тогтвортой үлдсэн. Дундаж цагын цалин өмнөх сараас 0.2%-иар нэмэгдсэн. Энэхүү хүлээлтээс давсан ажил эрхлэлтийн мэдээлэл хөрөнгө оруулагчдын таамаглалыг давж, баасан гарагийн өглөөний арилжаанд хувьцааны үнэд эерэгээр нөлөөлөв.

АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ АГШЛАА

АНУ-ын эдийн засаг 2025 оны I улиралд агшлаа. АНУ-ын Эдийн Засгийн Шинжилгээний Товчоо (BEA)-ноос лхагва гарагт танилцуулсан урьдчилсан тооцоогоор, АНУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд жилийн үндсэн дээр 0.3%-иар агшсан нь 2022 оноос хойших анхны сөрөг үзүүлэлт боллоо. BEA энэхүү ДНБ-ий агшилтыг "импортын огцом өсөлт, хэрэглээний зардлын өсөлтийн удаашрал, төрийн зардлын бууралттай" холбон тайлбарлаж байна. Уг улиралд импорт огцом нэмэгдсэн нь компаниуд Трампын засгаас хэрэгжүүлж эхэлсэн тарифын өмнө идэвхтэй нөөц бүрдүүлсэнтэй холбоотой гэж дүгнэжээ. Эдгээр тарифын ихэнх нь дөрөвдүгээр сарын эхээр хүчин төгөлдөр болсон.

Инфляци тогтвортой, хэрэглээ нэмэгдэв. Үүний зэрэгцээ, BEA-гээс мэдээлснээр, Холбооны Нөөцийн Сангийн инфляц хэмжих гол үзүүлэлт болох Хувийн Хэрэглээний Зардлын Үнийн Индекс (PCE Price Index) гуравдугаар сард сарын харьцуулалтаар өөрчлөгдөөгүй, харин хэрэглээний зардал 0.7%-иар өссөн байна. Энэ нь инфляци буурч, хэрэглээний идэвх сулраагүй гэдгийг харуулж байгаа бөгөөд эдийн засаг улирлын төгсгөлд харьцангуй сайн нөхцөлд байгааг илтгэжээ. Гэсэн хэдий ч уг тайланд Трампын хэрэгжүүлж буй сүүлийн үеийн тарифын ихэнх нөлөөлөл хараахан тусгагдаагүй байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.04.28 – 05.04

БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ АМРАЛТТАЙ БАЙНА

Onshore зах зээл дэх голлох CSI 300 индекс 0.43%-иар, Shanghai Composite индекс 0.49%-иар буурсан байна. Харин Хонконгийн Hang Seng индекс 2.38%-иар өсөв. Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл тавдугаар сарын 1-нээс 5-ны өдрүүдэд Хөдөлмөрийн баярын амралтаар хаалттай байгаа бөгөөд арилжаа тавдугаар сарын 6-ны Мягмар гарагт дахин эхэлнэ.

Баасан гарагт Хятадын Худалдааны яамнаас АНУ-тай худалдааны хэлэлцээр эхлүүлэх боломжийг судалж байгаа талаар мэдэгдэв. "АНУ нь сүүлийн үед холбогдох сувгуудаар дамжуулан Хятадтай хэлэлцээр эхлүүлэх хүсэлт илэрхийлсэн. Одоогоор Хятад тал энэ асуудлыг судалж байна" гэж тус яам мэдэгдсэн байна.

Хятад улс АНУ-аас оруулж буй ойролцоогоор 40 тэрбум ам.долларын импортын бараанд ногдуулсан тарифын заримыг хөнгөлөхөөр ажиллаж буй тухай Bloomberg агентлаг мэдээллээ. Эм бэлдмэл, үйлдвэрлэлийн химийн бодис зэрэг бараануудыг тарифын хөнгөлөлтөд хамруулах талаар мэдээлэл зах зээл дээр тархаад байгаа ч албан ёсоор баталгаажуулж байгаа аж (Bloomberg, нэрээ нууцалсан эх сурвалжуудаас иш татан мэдээлжээ).

Түүнчлэн дөрөвдүгээр сард АНУ ихэнх Хятадын бараанд 145% тарифыг ногдуулсны дараах эдийн засгийн нөхцөл байдлыг харуулсан анхны хоёр гол үзүүлэлт нийтлэгдлээ. Үйлдвэрлэлийн худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) гуравдугаар сарын 50.5-аас дөрөвдүгээр сард 49 болж, хүлээлтээс илүү буурч, 2023 оны арванхоёрдугаар сараас хойших хамгийн муу үзүүлэлт боллоо.

Харин үйлдвэрлэлд хамаарахгүй үйлчилгээ, барилгын салбарын PMI гуравдугаар сарын 50.8-аас 50.4 болж буурч, бас л хүлээлтэд хүрсэнгүй. БНХАУ энэ жил эдийн засгийн өсөлтийн зорилтот түвшинг 5% орчим гэж зарласан. Гэвч олон шинжээч энэхүү зорилтыг биелүүлэхэд хэцүү гэж үзэж байна. Учир нь АНУ-тай үүсээд буй худалдааны дайн нь экспорт болон бизнесийн итгэлд цохилт үзүүлэх магадлалтай. Гэсэн ч Бээжин ийм нөлөөллүүдийг бууруулах санхүүгийн бололцоотой бөгөөд эдийн засагт учрах өртгийг ажиглан үнэлсээр шат дараатайгаар төсвийн тэлэлт хэрэгжүүлэх боломжтой гэж шинжээч үзэж байна.

Golomt_Capital published on TradingView.com, May 04, 2025 23:41 UTC+4

Alibaba Group Holdings Ltd. - 1W - NYSE 0119.50 H126.62 L117.29 C125.76 +5.48 (+4.56%) +5.23 (+4.34%)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning April 28, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 DPZ MGM	 WM WASTE MANAGEMENT	 SOFI	 V VISA	 HUM Humana	 MSFT Microsoft	 LILY	 AMZN amazon	 FUBO fuboTV			
 MGM RESORTS INTERNATIONAL	 NXP	 PYPL PayPal	 SBUX Starbucks	 CAT CATERPILLAR	 META Meta	 RBLX ROBLOX	 AAPL Apple	 XOM ExxonMobil			
 OPRA Opera	 FFIV f5	 UPS	 SNAP Snap Inc.	 VMC Vulcan Materials Company	 HOOD Robinhood	 CVS CVS Health	 Riot	 AES aes			
 FMX FEMSA	 NUE NUCOR	 JBLU jetBlue	 SLR First Solar	 WDC Western Digital	 QCOM Qualcomm	 MCD McDonald's	 RDDT reddit	 CVX Chevron			
 ROP Roper Technologies	 TER TERADYNE	 RCL Royal Caribbean Group	 PPG	 IP INTERNATIONAL PAPER	 GRBK GREEN BRICK PARTNERS	 SIRX SiriusXM	 AGNB airbnb	 APO APOLLO			
 BKU BankUnited	 WELL welltower	 KO Coca-Cola	 BKNG BOOKING HOLDINGS	 GNRC GENERAC	 ALB ALBEMARLE	 MA Mastercard	 BBAI BIG BEAR AI	 BEP Brookfield			
 BMRC Bank of Marin	 ABCB AMERIS BANK	 PFE Pfizer	 QROV QORVO	 SMG Scotts Miracle-Gro	 NLY ANNALY	 BAX Baxter	 TEAM A. ATASSIAN	 CIG Cigna			
 RVTY revvity	 AMKR Amkor Technology	 SPOT Spotify	 ONEOK	 WGS GeneX	 CP	 BLDR Builders FirstSource	 TWLO twilio	 MGA MAGNA			
 CX CEMEX	 RIG Transocean	 MO Altria	 TTT TETRA	 HES HESS	 PPC pilgrim's	 MRNA moderna	 ROKU Roku	 BBU Brookfield			
 ARLP ALLIANCE RESOURCE PARTNERS LP	 RMBB Rambus	 FOUR Shift4 Payments	 WGL newgold	 ETSY Etsy	 SFM SPROUTS FARMERS MARKET	 PWR QUANTA SERVICES INC.	 AIG	 AXL AMERICAN AXLE & MANUFACTURING			

<http://eps.sh/cal>

© 2025 Earnings Whispers

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		May 05, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
 TGTX TG Therapeutics	 PLTR Palantir	 CELH CELSIUS	 AMD	 UBER	 APP APPROVIN	 PTON PELOTON	 TTD theTradeDesk	 WULF TERAWULF			
 BRKB Berkshire Hathaway Inc.	 HIMS hims hers	 DOOG DATADOG	 SMCI SUPERMICRO	 DIS Walt Disney	 CVNA CARVANA	 SHOP shopify	 COIN coinbase	 DRBS 1DIBS			
 ON onsemi	 F Ford	 RACE Ferrari	 TEM TEMPUS	 NVO Novo Nordisk	 ARM	 COP ConocoPhillips	 MAR MARATHON	 ENB ENBRIDGE			
 BCRX bioCryst	 O REALTY INCOME	 CEG Constellation	 RIVN RIVIAN	 U unity	 AXON	 QNST D:wave	 MELI mercado libre	 AQN Algonquin			
 RXRX Recursion	 VRTX Vertex	 DOCN DigitalOcean	 ET ENERGY TRANSFER	 VST VISTRA ENERGY	 CLF CLIFFS	 HUT HUT 8	 NET CLOUDFLARE	 ANIP ani			
 AXSM axsome	 EVER EVERQUOTE	 FIS FIS	 UPST Upstart	 TEVA teva	 IONQ	 WBND WARNER BROS. DISCOVERY	 SOUN SoundHound	 PAA PLAINS ALL AMERICAN PIPELINE CO.			
 TSN Tyson	 WMB Williams	 MAR Marriott International	 ANET ARISTA	 GOLD BARRICK	 OXY OXY	 CRON CRONOS GROUP	 DRAFT DRAFT KINGS	 TXMT TELUS International			
 FL Foot Locker	 CTRA COTERRA	 PRTH PRIORITY TECHNOLOGY HOLDINGS	 ALAB Asteralabs	 JCI Johnson Controls	 AMC amc	 CROX crocs	 WOLF WolfSpeed.	 TSL Telus			
 FRPT freshpet	 BBRE bellring	 WYNN Wynn Resorts	 KGC KINROSS	 OSCR Oscar	 BROS Dutch Bros	 ACMR ACM RESEARCH	 CLEAN CLEANSPARK AFIRM	 TXNM TXNM ENERGY			
 BNTX BIONTECH	 ICHR ichor	 IPG IPG PAPER		 FLEX	 FTNT FORTINET	 YETI	 AFFM affirm	 PAR par			

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers